

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Баттогтох	Дугаар	L149
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Бууцагаан
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Ловон лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дарь эхийн хийд	Сүм хийдийн дугаар	БХБН 077
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 12	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Дарь эхийн хийд

Асуулт:-Та хийдийнхээ талаар ярьж өгнө үү.

Хариулт:-Манай хийд анх 1992 онд анх үүсгэн бий болсон гандан байгаа. Манай энэ гандан дээр үеэсээ тойргийн улс орондоо Дарь эхийн жас гэж нэлээн өргөн хүрээтэй тийм том олон жас дуганаас бүрдэж бий болсон тийм хийд байсан байгаа юм. Манай хонь гэхэд 10 мянга хүрч, түм хүрч Богд хаанаас том хүрэл тогоогоор шагнагдаж байсан ийм түүхтэй байдаг. Хүрэл тогоо нь улсын төв музейд байрладаг гэж манай хөгшчүүл дээр үеэс ярьж байсан.

1992 оноос сэргээгдсэнээс хойш 1997 он хүртэл тогтмол хэвийн ажиллагаатай, үйл ажиллагаа явуулж байгаа. Тэрнээс хойш нэг хэсэгтээ завсардсан. Энэ хугацаанд лам нар нь хөдөө мал хуй маллаж, бас тухайн нийгмийнхээ юуг дагаж хурал хийддээ ирж амжихгүй байснаас болж хуучин нэлээн удаж байж боссон. Бас тухайн үедээ стандартад таараагүй барилга байж байгаад, тэгээд 2000 онд энэ хийдийн үйл ажиллагааг дахин сэргээхээр болж Тогоогийн Төгс гэж залуу манай хамба байсан, тэр бид хоёр ярьж хэлэлцээд, Засаг захиргаа,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Иргэдийн төлөөлөгчдийн хуралтайгаа ярьж зөвлөөд Иргэдийн хурлаас дэмжсэн, тэгээд нутаг орон маань ч сайхан дэмжсэн. Тэрнээс хандив цуглуулаад 2001 оны 5 сарын эхээр шинэ гандангаа бий болгож, өргөтгөж, бүрэн хэмжээний засвар хийгдэж ингэж орсон. Энэнээс хойш үйл ажиллагаа маань байнга, хурал ном маань байнга болж, тэрнээс хойш шавь болон шавь бологсдыг бүртгэн элсүүлж авч, бас их дээд сургуульд суралцах, оюутнуудыг бас дэмжих зорилгоор өөрийн дотооддоо бас нэлээн бодлого явуулж байгаа юм. Ийм ажиллагаатай манай гандан хийд явагдаж байгаад саяхан хөрөнгийн шинэчилсэн бүртгэл давхар хийгдэж, иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэг ширхэг нь очсон байгаа. Иргэдийн төлөөлөгчдийн хурал гэдэг маань бас манай удирдах ёсны байгууллага гэдэг утгаараа ийм юм шаардаж байдаг учраас өгсөн. Сая бас дээд удирдлагаас мэдэгдэл ирээд гэрчилгээний дугаар, гэрчилгээ, байршлыг аймаг руу **явуулчихаад** одоо ирэхийг нь хүлээгээд байж байна.

Асуулт:-Өдөр тутмынхаа уншлага номын талаар ярьж өгнө үү.

Хариулт:-Дээр үеийн жаяг дэгээр бол манайх нэлээн бас өргөн хүрээтэй хурал хурдаг байснаас эндээ цөөвтөр хүнтэй, шинийн 8, 15, мацаг өдрүүд, шинийн 8-нд Дарь эхийн мандал хурж өргөдөг. Шинийн **15-нд буяны** юм, Дарь эхийн мандал хоёроо давхар өргөж байдаг. 29-нд мөн **догшид** ном судрыг айлтгаад битүүндээ бас буяны ном хурдаг. Үдээс хойш бол дандаа хүний захиалга, буяны ном судар уншдаг.

Асуулт:-Одоо хэдэн ламтай хурал хурж байна.?

Хариулт:-Одоогоор гадуур явж байгаатай нийлээд 12 лам. Өнөөдрийн хуралд 3 лам сууж байгаа, бусад нь хөдөө гадаа, хүүхэд голдуу суудаг. Зуны улиралд мал хуй гээд ээж аавыгаа дагаад мал дээр гараад, намар 9 **сараас** хаврын 5 сар хүртэл 10-12 ламтай байдаг даа.

Асуулт:-Хийдийн лам нараас шашны дээд сургууль болон Энэтхэг, Төвдөд хүн сурч байна уу?

Хариулт:-Одоохондоо алга, энэ жил Ууганбаатар гэж залууг явуулах гээд байна. Энэ жил бас ХААИС төгсөөд ирж байгаа юм. Энийг бас явуулдаг юм билүү, залуу улсууд, бас боловсон хүчнээ бэлдэж авахгүй бол болохгүй. Одоо ингээд чадвал хот руу, найз **нөхөдтэйгээ** ярьж байгаад энэ хүнийг оруулдаг юм билүү гэж санаад байна.